

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Зам, тээврийн хөгжлийн яам
Огноо. 2018.01.31

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг

Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Биелэлт
<p>Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:</p>	<p>Арга хэмжээ: Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, /2017-2022/</p> <p>Биелэлт: Тус яамнаас 2017 онд төрийн албан томилогдохоор нэр дэвшсэн 28 нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлсэн ба АТГ-аас эдгээр нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянаж, албан бичиг ирүүлснээс шаардлага хангаагүй 2 иргэнийг албан тушаалд томилоогүй, мөн компанийн захирлаар бүртгэлтэй 2 нэр дэвшигчийн холбогдох асуудлыг шийдвэрлүүлж, нийт 22 нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилсон.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасны дагуу энэ онд тус яамны захилгын дагуу 6 ажлын байрны сул орон тоог нөхөх нээлттэй шалгаруулалтыг ТАЗ-өөс зохион байгуулж, шалгалтад хамгийн өндөр оноо авсан 6 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн тогтоолын дагуу томилсон. Мөн ТАЗ-өөс 13 иргэнийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөөс нэр дэвшүүлж ирүүлсэн. Мөн тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс яамны 4 хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтын дүн, комиссын тайлан, дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, мэдлэг боловсрол, туршлага, ур чадвар болон сонгон шалгаруулалтын дүнгээр тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан 4 албан хаагчийг хэлтсийн даргын албан тушаалд тус тус нэр дэвшүүлж, ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тухайн албан тушаалд томилсон.</p> <p>Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолыг яамны дотоод удирдлагын цахим системд болон яамны цахим хуудсанд байршуулж албан хаагч, олон нийтэд мэдээлсэн. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай АТГ-аас ирүүлсэн албан бичгийг олон нийтэд нээлттэй мэдээлээгүй болно.</p> <p>Арга хэмжээ: ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах /2017-2019/</p> <p>Биелэлт: Тус яамнаас 2017 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 28 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар АТГ-т хүргүүлсэн ба урьдчилсан мэдүүлэгт ажлын байрны тодорхойлолт, нэр дэвшигчийн анкет, холбогдох бусад баримт бичгийг хавсаргаж хүргүүлсэн. 2018 оны 1 дүгээр сараас эхлэн ХАСУМ-д хавсаргаж хүргүүлэх баримт</p>

бичигт Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулж байна. Тухайлбал, ТАЗ-ийн 2017.12.27-ний өдрийн 189 дүгээр тогтоолоор нэр дэвшиж ирүүлсэн Д.Бямбасүрэн, Э.Шаарийбуу нарын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэхдээ ТАЗ-ийн тогтоолыг хавсаргаж хүргүүлсэн болно.

Арга хэмжээ: Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох /2017-2022/

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” буланд яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн орон тоо, албан хаагчдын нэрсийн жагсаалтыг байршуулсан.

Тус яамнаас 2017 онд нийт 34 албан хаагч үүрэгт ажлаас чөлөөлөгдснөөс 14 нь өөр ажилд шилжсэн, өөрийн хүсэлтээр 5, тэтгэвэрт гарсан 3, Төрийн албаны тухай хуулийн 6.4-т заасан үндэслэлээр 3, түр орлон гүйцэтгэх хугацаа дууссан 1, сургалт болон эрүүл мэндийн шалтгаанаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 8 албан хаагч тус тус байна.

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон, гурван сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон зэрэг үндэслэлээр түр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн санг бүрдүүлж, бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг эрхлэн гүйцэтгэж байна. Тус яамны төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд эрүүл мэндийн байдлаас төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 6, сургалтад хамрагдах зорилгоор төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 16, төрийн өөр албан тушаалд томилогдож чөлөөлөгдсөн 1 албан хаагч тус тус бүртгэлтэй байна.

Яамны дотоод удирдлагын цахим системийн Хүний нөөцийн хэсэг, мөн Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системд томилогдсон, чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг бүртгэж, албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг тогтмол тайлагнан ажиллаж байна.

Арга хэмжээ: Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх /2017-2022/

Биелэлт: Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн ажлын байрны тодорхойлолтод тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг нарийвчлан тусгаж баталгаажуулсан ба ингэхдээ яамны газрын дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний түвшинд тавигдах мэргэжил, мэргэшил, туршлагын жишиг шаардлагыг тогтоож авч үзсэн болно.

Ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй иргэдийг шалгаруулж сул орон тоонд томилон ажиллуулж байна.

Арга хэмжээ: Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх /2017-2019/

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагуудад ёс зүйн хэм хэмжээ, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарч, тэдгээр байгууллагуудад мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрэмд өнгөрсөн онд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж өгсний дагуу байгууллага бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу ёс зүйн дүрмээ шинэчилж хариуцлагын хэм хэмжээг тодорхой болгох, ёс зүйн хороог байгуулах, шинэчлэх, ажиллах журмыг тогтоох, хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллалаа.

Яамны албан хаагчдын хөдөлмөрийн сахилга бат, ажлын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, хөдөлмөрийн дотоод журмын мөрдөлтийг сайжруулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ажлын цаг ашиглалтад байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, зөрчил гаргасан албан хаагчид хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага тооцож ажиллалаа. Тухайлбал, 2017 онд ажлын хариуцлага алдсан, ажлын цаг ашиглалт хангалтгүй байсан 13 албан хаагчид ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдууллаа.

Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн ажлаа бүрэн, оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, биелэлтийг хангах үйл явцад удирдах албан тушаалтнаас байнгын хяналт тавьж, ажлын гүйцэтгэл, үр дүнг 7 хоног бүрээр гаргаж, тайлан төлөвлөгөө хангагдаагүй тохиолдолд тухайн албан хаагчийн үр дүнгийн гэрээний үнэлгээг бууруулах, гүйцэтгэлийг сайуруулах арга хэмжээ авч ажиллалаа.

Арга хэмжээ: Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /2017-2022/

Биелэлт: Цахим албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дотоод удирдлагын цахим систем дээр “Албан хэрэг төлөвлөлт” модулийг шинээр хийлгэхээр “Эйбл Софт” ХХК-ийн холбогдох ажилтнуудтай хамтран ажиллаж процессийн зураглал, системийн шинжилгээ боловсруулан, програмчлалын ажлыг эхлүүлсэн.

Мөн албан бичиг модулийн байнгын ажиллагааг ханган, алдаа гарсан үед яаралтай засварлах, хөгжүүлэлт хийх чиглэлээр Эйбл Софт ХХК-тай байнга хамтран ажиллаж, явсан бичгийн хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал тайлангийн алдааг засварласан, хөтлөн удирдах эрхтэй хэрэглэгчид хаалт хийх эрх олгосон, явсан бичгийн бүртгэлийн “Хариу ирээгүй бичгийн тайлан” дээр олон байгууллагад явуулсан бичгийн хариуг ялгаж харуулдаг болгосон, ирсэн, явсан бичгийн бүртгэлийн холбоосыг шалгаж хаалт хийгддэг болгосон, явсан бичиг бүртгэх үед олон байгууллага мэдээллийн сангаас сонгож оруулах боломжийг бүрдүүлсэн зэрэг өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийсэн.

Төрийн байгууллагын Интранет системийн ашиглалтын байдлыг 2017 оны 4 дүгээр сард харьяа байгууллагуудын хэмжээнд хянан үзэхэд, ашиглалт хангалтгүй байсан тул Интранет системийн ашиглалтыг сайжруулах, байнгын ажиллагаатай байлгах үүрэг

	<p>чиглэлийг харьяа байгууллагуудад өгч, бичиг хэргийн ажилтнуудын мэдээллийг шинэчилж, нэвтрэх эрхүүдийг сэргээсний зэрэгцээ харьяа байгууллагуудын бичиг хэргийн ажилтнуудад сургалт явуулж, заавар зөвлөгөө өгсөн болно. Мөн Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор харьяа байгууллагуудын мэдээллийн технологийн ажилтнуудад зориулсан сургалтыг Үндэсний дата төвтэй хамтран зохион байгуулсан.</p>
	<p>Арга хэмжээ: Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах /2017-2019/</p>
	<p>Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тушаалаар Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны сургалтын төлөвлөгөөг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга баталсан ба төлөвлөгөөнд нийт 24 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс тайлант хугацаанд 19 сургалтыг зохион байгуулж, 5 сургалт санхүүжилтийн асуудлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй байна. Тайлант хугацаанд дотоод сургалтад давхардсан тоогоор 214 албан хаагч, гадаад сургалтанд 20 албан хаагч тус тус хамрагдсан байна. Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчилж Авлигатай тэмцэх газартай хамтран яамны болон харьяа байгууллагын албан хаагчдад нийт 3 удаа сургалт зохион байгуулав.</p>
	<p>Арга хэмжээ: Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах /2017-2019/</p>
	<p>Биелэлт: Засгийн газрын 1996 оны 265 дугаар тогтоолын дагуу яамны албан хаагч нарт зориулсан мэдээлэл, сурталчилгааны “Мэдээллийн цаг” арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулж, үүнд Зам, тээврийн яам болон харьяа байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан. Мөн Зам, тээврийн хөгжлийн Төрийн нарийн бичгийн даргаар 2017 оны сүүлийн хагас жилд зохион байгуулах “Хууль-эрх зүй” сэдэвт сургалтын төлөвлөгөөг 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр батлуулж, төлөвлөгөөний дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Авто замын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, Иргэний нисэхийн ерөнхий газрын албан хаагчдад Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Автозамын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлан мэдээлэл өгч ажиллаж байна.</p>
<p>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж,</p>	<p>Арга хэмжээ: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим</p>

<p>цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</p>	<p>хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах /2017-2018/</p> <p>Биелэлт: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох зэрэг үйл ажиллагааг цахимжуулах асуудлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хөтөлбөрийг хэрэгүүлэх төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар санал өгсөн. Тус яамнаас тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем боловсруулах төсөл боловсруулж, програм хангамжийн компаниудаас үнийн санал авч удирдлагуудад төслийг танилцуулсан. Одоогоор хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.</p> <p>“Цахим систем болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх төсөл”-ийн “Төрийн Энтерпрайз Архитектур боловсруулах зөвлөх үйлчилгээ” ажлын хүрээнд 167 үйлчилгээнээс ЗТХЯ-ны дараах 6 үйлчилгээг цахимжуулахаар тогтсон.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг бүртгэж, улсын дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох ▪ Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олгох ▪ Авто тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн ▪ Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа авах ▪ Явуулын дугаар олгох ▪ Авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний түүх харах. <p>Дээрх төсөл хэрэгжиж дуусч байгаатай холбогдуулан бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах туршилт хийгдэнэ. Цаашид Автотээврийн салбарын хэмжээнд олгогдож байгаа тусгай зөвшөөрөл, ачаа тээврийн эрх олгох зэрэг үйлчилгээг цахимжуулах, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажил хийгдэнэ. Мөн одоо ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийн систем техник, технологийн хоцрогдолд ороод байгаа тул шинэчлэх ажлыг эхлүүлнэ.</p> <p>Арга хэмжээ: Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх /2018-2022/</p> <p>Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн яамнаас харьяа агентлаг, байгууллага болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжид Автотээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хянан шалгаж, төмөр зам, авто зам, автотээвэр, далай ашиглалт, усан замын тээврийн салбарын аюулгүй байдлыг хангах, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд төлөвлөгөөт 19, төлөвлөгөөт бус 21, гүйцэтгэлийн 20 шалгалтыг явуулж, тандалт судалгаа 1, зөвлөн туслах үйлчилгээ 4 үзүүлсэн байна.</p> <p>Хяналт шалгалтад 161 аж ахуйн нэгж, байгууллага, 21 иргэн хамрагдаж, нийт 893 зөрчил илрүүлж, 724 зөрчлийг арилгуулж, 50 зөрчилд 19.9 сая төгрөгийн захиргааны арга хэмжээ авсан байна. Мөн улсын байцаагчийн “Зөрчил арилгуулах тухай” 544 заалт бүхий 130 албан шаардлага, үйл ажиллагааны болон бүтээгдэхүүний 42 дүгнэлт, 13 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, үйл ажиллагааг түр зогсоох тухай</p>
---	--

	<p>улсын байцаагчийн 2 акт, сэргээх тухай 2 актыг тус тус үйлдсэн байна.</p> <p>Тээвэрлэлтийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорилгоор тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад 33 сургалт зохион байгуулж, нийт 1457 хүнийг хамруулсан байна.</p> <p>2018 онд урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах чиглэлээр МХЕГ-тай хамтран хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг 2017 оны 12 дугаар сард батлуулан ЗТХЯ-ны цахим хуудас дээр байршуулав.</p> <p>Арга хэмжээ: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх /2017-2022/</p> <p>Биелэлт: Зам, тээврийн салбарын ажил үйлчилгээнд Төрийн бус байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний тендерийг жил бүр зарлаж, яамны үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж байна. ЗТХЯ-ны 2016 оны үйл ажиллагаанд Хэрэглэгчийн үнэлгээ хийсэн ажлын тайланг 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/1227 албан тоотой ЗГХЭГ-т хүргүүлэв. Яамны 2017 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний багийг шалгаруулах үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна.</p>
<p>Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</p>	<p>Арга хэмжээ: Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх /2017-2022/</p> <p>Биелэлт: Тус яамны ХШҮДАГ-аас 2017 онд дараах харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төслийн хэрэгжилт, зээлийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалтын байдалд санхүүгийн шалгалт хийж, дүгнэлт гаргав. 2. ИНЕГ-ын 2012-2016 он, 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн ажиллагаанд Сангийн яамтай хамтран шалгалт хийв. 3. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын харъяа Сэлэнгэ, Орхон, Архангай аймгийн Автотээврийн төвүүдийн 2016, 2017 оны эхний 5 сарын санхүүгийн үйл ажиллагаа, хүний нөөц, цалингийн сан, гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд шалгалт хийв. 4. Улсын төсөв, зээл тусламж, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, их засвар, шинэчлэлтийн ажил хийгдсэн авто зам, замын байгууламжийн ажлын явцад тогтмол хяналт тавин ажиллаж байна. <p>Арга хэмжээ: Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах /2017-2019/</p> <p>Биелэлт: Ил тод байдлыг хангах чиглэлээр хуульд заасан болон цаг үеийн олон нийтэд мэдээлэх шаардлагатай нийт 376 гаруй мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны www.shilendans.gov.mn сайтад Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн холбогдох ажилтнууд мэдээллийг оруулдаг бөгөөд яамны вэб сайтад "Шилэн данс" үндсэн цэс үүсгэн Төрийн ерөнхийлөн захирагч, Яам, Шилэн дансны хяналт булангуудад холбогдох мэдээлэл болон холбоосыг оруулан ажиллаж байна.</p>

	<p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр Замын сангийн төсвийн зарцуулалтын мэдээллийг сар бүр олон нийтэд мэдээлж байна.</p> <p>Түүнчлэн шилэн дансны “хяналт” буланд Хуулийн хяналтыг сайжруулах тухай Сайдын 2017 оны 102 дугаар тушаал, Төсвийн ерөнхийлөн захирагч, яам, харьяа агентлаг, төсөвт байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, хуулийн хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагч, Зам, тээврийн хөгжлийн сайдын харьяа байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудит зэрэг мэдээллийг байршуулсан. Худалдан авах ажиллагааны ил тод байдал булан ажилуулж, Тендерийн урилга 10, Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 оны 02 дугаар сарын Худалдан авах ажиллагааны тайлан, Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 оны III улирлын худалдан авах ажиллагааны тайлан, Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө зэрэг мэдээллийг байршуулсан байна.</p> <p>Арга хэмжээ: Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх /2017-2020/</p> <p>Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлэх хуваарьт Засгийн газрын тусгай сан Замын сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын мэдээллийг хариуцах албан хаагч, мэдээлэх хугацааг тодотгож оруулав. Замын сангийн мэдээллийн ил тод байдлыг 2017 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 70%-ийн үнэлгээ авсан. Замын сангийн төсвийн зарцуулалтын хэмнэлт, хэтрэлттэй холбоотой тайлбарыг мэдээллийг цахим хуудсанд оруулахаар бэлтгэж байна.</p> <p>Арга хэмжээ: Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах /2017-2022/</p> <p>Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын төсвийн төслийг харьяа байгууллагуудын хэмжээнд хэлэлцүүлж, санал авч, саналыг тусган ажиллаж байна.</p> <p>Арга хэмжээ: Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх /2017-2019/</p> <p>Биелэлт: Аудитын дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, нэгдсэн тайлан гарган удирдлагад танилцуулан ажиллаж байна. Улсын байцаагчийн шалгалтаар нийт 893 зөрчил илрүүлж, 724 зөрчлийг арилгуулж, 50 зөрчилд 19 925 000 төгрөгийн захиргааны арга хэмжээ тооцож, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.</p>
<p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн</p>	<p>Арга хэмжээ: Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах /2017-2018/</p>

байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтын хүрээнд:	<p>Биелэлт: Тус яамнаас шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн оролцоог хангах хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.</p> <p>Өнгөрсөн онд тус яамнаас Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг хэрэгжүүлж, хуулийн төслийг салбарын байгууллагуудын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн, санал дүгнэлтийг аван ажиллаж байна. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг ИНЕГ-ын холбогдох шатны удирдлагууд, салбарын байгууллагуудыг оролцуулан зохион байгуулав. - Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, автотээврийн салбарын байгууллагуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 54 байгууллагын 120 төлөөлөгч оролцуулан зохион байгуулав. Мөн Байгалийн шингэрүүлсэн хий, байгалийн шахсан хий ашиглах, импортлох асуудлаар төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй; Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг устгах, дахин боловсруулах талаар төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй; Баруун гар талдаа жолооны хүрдтэй болон өндөр насжилттай тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах тухай асуудлаар Монголын автомашин дистрибьютирүүдийн холбоо, Монгол дах Америкийн худалдааны танхим, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй; Дотоодын ачаа тээврийг зохицуулах, зохион байгуулах талаар Нийслэлийн тээврийн газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Хөдөө аж ахуйн бирж”, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Монголын автотээврийн мэргэжлийн холбоо, Монголын махны холбоо, “Монгол тээвэр нэгдэл”, “Хүчит шонхор” ХХК, “Барс импекс” ХХК-ийн төлөөлөлтэй; Такси үйлчилгээний талаар Нийслэлийн тээврийн газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Такси эрхлэгчдийн холбоо болон таксийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй тус тус уулзалт ярилцлага, хийж, санал авсан байна. - Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, "Монголын төмөр зам" ТӨХК, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн албан хаагчдын дунд явуулж, санал зөвлөмжийг авч ажиллав.
	<p>Арга хэмжээ: Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх /2017-2019/</p> <p>Биелэлт: Тээвэр, авто замчдын үйлдвэрчний эвлэлийн холбоод, ажил олгогч талын төлөөлөлтэй хамтран 3 талт хэлэлцээр байгуулан ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлж байна.</p>
	<p>Арга хэмжээ: Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах /2017-2022/</p>

	<p>Биелэлт: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг бий болгох зорилгоор авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөлийг тус яамны дэргэд байгуулсан.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Авлигатай тэмцэх газрын Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Цэцэгдэлгэрэх нар тус яамны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах иргэн Г.Сундуй, Д.Оюун-Эрдэнэ, П.Мэндбаяр нартай 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулсан.</p>
<p>Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</p>	<p>Арга хэмжээ: Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах /2017-2022/</p> <p>Биелэлт: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг яамны цахим хуудсанд болон яамны дотоод удирдлагын цахим системд, хөрөнгө орлогын цахим мэдүүлгийн холбоосыг mrt.d.gov.mn/ цахим хуудсанд тус тус байрлуулав. Мөн дотоод удирдлагын цахим системд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах гарын авлага, сургалтын материал зэргийг байршуулж, албан хаагч нарт холбогдох мэдээллийг тухай бүр хүргэсэн.</p> <p>Мөн Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчилж Авлигатай тэмцэх газартай хамтран яамны болон харъяа байгууллагын албан хаагчдад нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулав.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалтыг гаргаж, Авлигын эсрэг хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээлгэсэн үүрэг, хариуцлагын талаар 800 гаруй албан хаагчдад 2017 онд 38 цагийн сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан “Хууль-эрх зүй” сэдэвт сургалтын төлөвлөгөөний дагуу Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн асуудал” сэдвээр тус тус сургалтыг зохион байгуулж нийт 10 байгууллагад давхардсан тоогоор 700 гаруй албан хаагчийг хамруулсан байна.</p>
	<p>Арга хэмжээ: Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах /2017-2022/</p>

	<p>Биелэлт: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах зорилгоор арга хэмжээ тус бүрийг холбогдох нэгжийн дарга, албан хаагч нарт хариуцуулж, хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр дүнг тооцож, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээнд тус ажлын гүйцэтгэлийг үнэлэх байдлаар хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.</p>
<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Ололт: Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх болон авлигатай холбоотой зөвлөмж, мэдээллийг албан хаагч нарт хүргэж, сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй явуулж байгаа нь тодорхой эерэг нөлөөллийг үзүүлж байна.</p> <p>Анхаарах асуудал: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх” үйл ажиллагааны хүрээнд тус яамнаас үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох зэрэг үйл ажиллагааг цахимжуулах, түүнд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тусгаж саналаа өгсөн боловч төлөвлөгөөнд уг асуудал тусгагдаагүй бөгөөд 2018 оны төсөвт шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй.</p> <p>Түүнчлэн авлигаас урьдчилан сэргийлэх гол суурь асуудлын нэг болох төрийн албан хаагчдын цалин хөлс, тэдний нийгмийн асуудалд анхаарах явдал чухал байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 44.1.2-т заасан “өөрийн байгууллагын ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зохион байгуулах” үүргийн дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардал төсөвт тусгагдахгүй байна. Түүнчлэн албан хаагчдыг сургах, мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх зардал төсөвт тусгагдаж батлагдахгүй байгаагаас сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжих боломжгүй, мэргэжэл, мэргэшлийн хувьд албан хаагчдыг хөгжүүлэх боломжгүй байна.</p> <p>Иймд Авлигатай тэмцэх газраас Сангийн яаманд төсвийн төслийг хянах, нэгтгэн боловсруулах болон УИХ, Засгийн газрын хуралдаанаар төсвийн төсөл хэлэлцэх явцад төрийн байгууллагуудад зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнд шаардлагатай төсвийг тусгах, батлуулахад анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байна.</p>
<p>Санал</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны төв байгууллагуудын тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх асуудлыг нарийвчлан судалж, байгууллагуудын онцлогийг тусган, нэгдсэн, цогц байдлаар шийдвэрлэх, - АТГ-аас төрийн албан хаагчдын хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, албан үүргээ зөв, шударга хэрэгжүүлэхэд нөлөөлөх аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар албан хаагчдаас асуулга, судалгаа явуулах байдлаар судлан үзэж, үнэлэлт дүгнэлт өгөх.
<p>Шаардагдах төсөв</p>	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнээс төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээнд тодорхой хэмжээний хөрөнгө шаардагдахаар байгаа бөгөөд бусад арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой байна. Тус яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, лиценз, эрх</p>

		олгох зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд урьдчилсан судалгаагаар 30-40 сая төгрөг шаардлагатай байгаа болно.			
Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна.			
Сургалтад хамруулах албан хаагчийн тоо		Авлигатай тэмцэх газрын авлигын эсрэг сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу улиралд 42, жилдээ 126 албан хаагч буюу нийт албан хаагчдын 90 гаруй хувийг сургалтад хамруулна.			
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	80.5%	3	90.3%	73.3%	78.0%
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 4	Зорилт 5	-
	81.6%	2	83.3%	80.0%	-

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ